

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2019 ОНЫ
4 ДҮГЭЭР САРЫН МЭДЭЭ**

Нэг.Удирдлага, зохион байгуулалтын талаар:

Аймгийн ИТХ-ын Төлөөлөгчдийн ээлжит бус Х хуралдаан 2019 оны 4 дүгээр сарын 3-ны өдөр хуралдаж

1. Аймгийн 2018 оны давсан орлого, дансны үлдэгдэл зарцуулах тухай
2. Хөвсгөл аймаг дахь уул уурхайн салбарын өнөөгийн байдал, цаашид анхаарах асуудлын тухай болон “Аспайр майнинг”ХХК-ийн мэдээлэл, Эрдэнэт-Овоотийн төслийн танилцуулга зэрэг асуудлыг хэлэлцлээ .

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид 2019 оны 4 дүгээр сарын 24-ны өдөр хуралдаж дараах асуудлыг хэлэлцэж тогтоол шийдвэр гаргалаа. Үүнд:

1. Орон нутгийн өмчийн төлөөлөгчийг томилж, ажиллах журам, эрх үүргийг батлах тухай
2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх тухай
3. Хөрөнгө шийдвэрлэх тухай
4. Үндсэн хөрөнгө актлах шилжүүлэх тухай

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс 2019 оны “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх”, “Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийг бууруулах жил” болгон зарлаад нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг зохион байгуулан ажиллаж байна.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс 2019 оны 6-7 дугаар сард хөдөөгийн сумдын 45 багт хүрч ажиллахаар төлөвлөж бэлтгэл ажлаа хангаж байна. Хөдөөгийн 45 багт шүүх, прокурор, цагдаа бусад хууль хяналтын байгууллага болон эрүүл мэнд, боловсрол, улсын бүртгэл, халамжийн үйлчилгээг хөдөөгийн багт хүргэж ажиллахаар төлөвлөж байна.

Мөн аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс иргэдэд хууль сурталчлах, тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад эерэг хандлага, зөв зан үйлийг төлөвшүүлэх сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Монгол Улсын хэмжээнд Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх “Байгалиа хамгаалъя” аян, “Нэг хором” аян “Зөв тусгал аян”, “Нуугдмал” аян, хуулийн байгууллагуудын “Про боно өдөрлөг” зэрэг үйл ажиллагаануудыг аймгийн хэмжээнд зохион байгуулан ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Үндэсний хөгжлийн газар, “Жайка” олон улсын байгууллага, Германы GIZ хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран “Бүсчилсэн хөгжлийн бодлогын хэлэлцүүлэг”-ийг зохион байгууллаа. Аймгуудын одоогийн нөхцөл,

тулгарч буй бэрхшээлүүдийн талаар тодруулж аймгийг хөгжүүлэх хэтийн зорилтыг тодорхойлж үнэлэх” цаашид аймагт хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийг боловсруулах зорилго бүхий энэ хэлэлцүүлэгт аймгийн ИТХ, агентлаг, байгууллагуудын дарга, сумдын Засаг дарга, ИТХ-ын дарга нар болон мэргэжилтнүүд, бизнес, хувийн хэвшлийн төлөөлөл оролцож санал бодлоо илэрхийллээ.

Хөвсгөл аймаг 2019 оныг “Хүүхэд хамгаалал, Өрхийн хөгжлийг дэмжих” болгон зарласан ба нэрлэсэн жилийн ажлын хүрээнд Хөвсгөл аймгийн хүүхдийн төлөө зөвлөлийн 2019 оны өргөтгөсөн хурал зохион байгуулагдлаа. Уг хурлаар Хөвсгөл аймгийн хүүхэд хамгаалал, хүүхдийн хөгжлийн талаар авч хэрэгжүүлж буй ажлын өнөөгийн нөхцөл байдал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар авч хэлэлцлээ. Хуралдаанд аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн гишүүд, сумдын засаг дарга нар, хүүхдийн өмнө үүрэг хүлээгч нар хамрагдсан байна.

“Дэлхийн Хөвсгөл” англи хэлний аймгийн дэд хөтөлбөр, “Цахим Хөвсгөл” “Найрсаг Хөвсгөл” гадаад харилцааны дэд хөтөлбөр, “ Төрийн албан хаагчдын сургалт” аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд аймгийн төрийн албан хаагчид, иргэдийн англи хэлний мэдлэг, чадварыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор англи хэлний олимпиадыг 3 ангиллаар зохион байгууллаа. Сумдын төрийн албан хаагчдын онлайн олимпиадад 17 сумын 78 , агентлаг, байгууллагуудын албан хаагчдын олимпиадад нийт 80 төрийн албан хаагч оролцлоо. Мөн англи хэл сонирхогч иргэдийн дунд олимпиад зохион байгууллаа.

Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг Засаг даргын нэрэмжит “Төрийн албан хаагчдын спортын тэмцээн амжилттай болж өндөрлөлөө. Энэхүү тэмцээн нь төрийн албан хаагчдын хөгжил, манлайлал, оролцоог нэмэгдүүлэх, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, баг хамт олны Зүтгэл, Итгэл, Сэтгэлийн хүчээр амжилтад хүргэх зорилготой юм. Тэмцээнд 22 сум, 22 агентлаг, байгууллагын 92 багийн 700 гаруй тамирчид сагсан бөмбөг, волейбол, ширээний теннис, удирдлагуудын дунд холын зайны шидэлт, гэсэн спортын 4 төрлөөр 64 багц медалийн төлөө хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдөж агентлаг байгууллагуудыг Цагдаагийн газар, сумдыг Цагаан-Уул сум тэргүүлж шилжин явах цомыг хүртлээ.

БНХАУ-ын Өвөр Монголын Шилийн гол аймагтай хамтран ажиллах эхлэл тавигдаж аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Г. Баттулга тэргүүтэй төлөөлөгчид энэ оны 4-р сард айлчлал хийлээ. Мөн Манжуур хотын Ардын Засгийн ордны Хэвлэл мэдээлэл болон гадаад харилцааны албаны төлөөлөл Хөвсгөл аймагт айлчлан хоёр орны соёл, хэвлэл мэдээлэл, худалдаа,эдийн засаг, аялал жуулчлал зэрэг олон салбарын харилцаа, хамтын ажиллагаанд гүүр болж хэвлэл мэдээлэл, соёл урлагийн байгууллагуудтай холбоо тогтоож уран бичлэг, фото зургийн үзэсгэлэн хамтран зохион байгуулах талаар санал солилцлоо.

Хоёр. Эдийн засаг,төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд:

Төрийн сангийн төлбөр тооцооны программаар 2019 оны 3-р сард 46 Төсөвт байгууллагын үндсэн болон нэмэлт санхүүжилтийн данснаас 15,8 тэрбум төгрөгийн 2,285 ширхэг гүйлгээ шивэгдсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн 2019 оны 3-р сарын мэдээгээр Орон нутгийн орлого, санхүүжилт 1,998,2 сая төгрөгний төлөвлөгөөтэйгээс 2,760,0 сая төгрөг буюу 138,1% хувийн гүйцэтгэлтэйгээр давуулан биелүүсэн байна.

Орон нутгийн болон тусгай шилжүүлгийн байгууллагуудын төсвийн зарлагын гүйцэтгэл батлагдсан төсөв 29,810,3 сая төгрөг байгаа бөгөөд үүнээс 14,150,4 сая төгрөг нь тусгай зориулалтын шилжүүлгээс, 13,534,7 сая төгрөг нь орон нутгийн байгууллагуудад олгох санхүү дэмжлэг болон аймаг сумын орлогоос, 78,7 сая төгрөг нь төсөвт байгууллагын өөрийн орлогоос, 975,8 сая төгрөг нь орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас тус тус санхүүжигдсэн байна. Төсвийн гүйцэтгэлийн мэдээнд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр 29,810,3 сая төгрөг, Зарлагын гүйцэтгэл 29,886,7 мянган төгрөг буюу 100.3% хувьтай байна. Энэ сарын төсвийн гүйцэтгэлийн хувьд Санхүү дэмжлэг болон Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт дутуу ирсэн.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр Төсвийн нийт авлага 700,7 сая төгрөг өмнөх сараас 516,7 сая төгрөгөөр өссөн байна.

Нийт өглөг 1,304,9 сая төгрөг өмнөх сараас 271,4 сая төгрөг буурсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны жилийн эцсийн Санхүүгийн тайлан Төрийн аудитаар орж хуулийн хугацаандаа “Зөрчилгүй” дүгнэлтийг авч Сангийн яамны Төв Төрийн сангийн газарт нэгтгүүлж байна.

Аж ахуйн нэгжийн 2019 оны 1-р улирлын Санхүүгийн тайлан хуулийн хугацаандаа Аймгийн Санхүү Төрийн сангийн хэлтэст нэгтгэгдсэн.

Аймгийн 2018 оны давсан орлого, дансны үлдэгдлийг аймгийн ИТХ-ын хуралдааны 2019.04.03-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор баталж нэн тэргүүнд шаардлагатай арга хэмжээ, хөтөлбөр төслүүдэд хуваарилагдсан байна.

2019 оны 04 сарын байдлаар нийгмийн даатгалын санд шимтгэлийн орлого 1750.2 сая төгрөг, сайн дурын даатгуулагчаас 140.9 сая төгрөгийн, шимтгэлийн орлого 118.5 % - аар биелсэн байна

Тэтгэврийн даатгалын сангаас 18352 тэтгэвэр авагчид 5965.3 сая төгрөгийн 3 төрлийн тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын сангаас 198 даатгуулагчдад 200.5 сая төгрөгийн тэтгэмжийн зардал, ажилгүйдлийн даатгалын сангаас 85 даатгуулагчдад 35.5 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж олгосон байна.

Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 409.4 сая төгрөг байна.

Аймгийн Татварын хэлтэс нь 4 дүгээр сард улсын төсөвт 166,4 сая төгрөг төвлөрүүлэхээс 358,6 сая төгрөг төвлөрүүлж 215.4 хувиар, аймгийн төсөвт 725,3 сая төгрөг 815,4 сая төгрөг төвлөрүүлж 112,4 хувиар, сум, орон нутгийн төсөвт 317,2 сая төгрөг төвлөрүүлэхээс 390,1 сая төгрөг төвлөрүүлж 122.8 хувиар тус тус давуулан биелүүлсэн байна.

2019 оны 1 дүгээр сараас эхлэн урьд оны хяналт шалгалтын өр төлбөртэй аж ахуй нэгжүүдийн төлөгдөөгүй өр төлбөрийг 2019 оны хагас жилд багтаан бүрэн барагдуулах зорилт тавин ажиллаж 2019 оны эхний 4 сарын байдлаар 20 гаруй сая төгрөгийн өрийг барагдуулаад байна.

Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Татвар төлөгчдийн өдрүүд” арга хэмжээг 5 дугаар сарын 2 дахь долоо хоногт аймаг, орон нутагт тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан 4 дүгээр сарын сүүлийн 10 хоногт тус өдрүүдийн бэлтгэл арга хэмжээг хангаж ажиллалаа.

Гурав. Хууль эрхзүйн бодлогын хүрээнд

Аймгийн Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газар, аймгийн ИТХ хамтран “ Байгалиа хамгаалъя” нэг сарын аяныг зохион байгуулж байна.

Чингүнжавын талбайд хуулийн байгууллагуудын нээлттэй хаалганы өдөрлөг арга хэмжээ зохион байгуулагдлаа. Өдөрлөгт аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс, Архивын тасаг, Шүүх, Прокурор, Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Татварын хэлтэс, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс, Шүүхийн шинжилгээний алба, Хууль зүйн туслалцааны төв, аймгийн өмгөөлөгчдийн зөвлөл, Монголын нотариатын танхим оролцож иргэдэд үйлчилж, мэдээлэл өглөө.

Аймгийн Засаг даргын 2019 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн А142 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг буюу Аймгийн Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газар, Улсын бүртгэлийн хэлтэс болон холбогдох байгууллагууд Мөрөн суманд үйл ажиллагаа явуулж байгаа захууд болон зах орчмын бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа, худалдаа үйлчилгээний цэгүүдэд хамтарсан үзлэг шалгалтын ажлыг зохион байгуулсан.

Аймгийн Онцгой байдлын газраас Галт, Жаргалант, Шинэ-Идэр, Төмөрбулаг сумдад ажиллаж Гамшгийн эрсдлийн судалгааны ажлыг зохион байгуулж ажиллав.

Энэ онд Төрийн байгууллагын удирдлага зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг, шалгалт Хөвсгөл аймагт явагдах бөгөөд үүнтэй холбогдуулан аймгийн ЗДТГ-ын Хууль, эрхзүйн хэлтсийн Архивын тасгаас сум, агентлаг, төрийн байгууллагуудын архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтнуудыг хамруулан сургалт зохион байгуулж мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө. Уг сургалтад 23 сум, 1 тосгон, 71 агентлаг, байгууллагын 100 гаруй албан хаагчид оролцож мэдээлэл авлаа.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:

Улсын төрөлжсөн олимпиадын гурвын даваанд Хөвсгөл аймгийн багш, сурагчид оюун ухаанаа сорьж одоогоор 5 алт, 2 мөнгө, 7 хүрэл медаль хүртсэн амжилтыг үзүүлээд байна.

"Эх хэл бидний бахархал" үндэсний бичиг үсгийн YII наадмыг аймгийн БСУГ, МУГБагш Д.Батсуурийн нэрэмжит Титэм ерөнхий боловсролын сургууль хамтран амжилттай зохион байгуулж өндөрлөлөө. Уг наадмаар 7 төрлийн арга хэмжээ явуулж, 60

гаруй шагналт байрыг тодруулан байгууллага, хамт олон, багш сурагчид, иргэдийг шагнаж урамшууллаа.

Аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар Дэлхийн зөн ОНХ-тэй хамтран Хөвсгөл аймгийн "Хүүхдийн найрал дууны анхдугаар наадам", "Бид ном унших дуртай" номын клубуудыг дэмжих аяны хүрээнд клубуудын гишүүдийн уулзалт сургалтыг зохион байгууллаа.

Дэлхийн тусгай олимпын наадмаас Мөрөн сумын 4-р багийн харъяат Титэм сургуулийн 8-р ангийн сурагч, Э.Энхбаяр, 100м-ийн төрөлд мөнгө, 200м-ийн төрөлд алтан медаль хүртсэн амжилтыг үзүүллээ.

Аймгийн нийтийн номын сангаас "Олон Улсын Хүүхдийн номын өдөр"-ийг тохиолдуулан дэлхийн сонгодог болон орон орны үлгэрийн дээжсээр "Үлгэрийн ертөнцөөр аялцгаая" номын үзэсгэлэнг 57 ширхэг номоор гаргалаа. Үзэсгэлэнг 20 хоног нийтэд зориулан гаргасан бөгөөд давхардсан тоогоор 300 орчим хүн үзэж сонирхлоо. Мөн Дэлхийн номын өдрийг тохиолдуулан номын санд фонд баяжилтаар ирсэн шинэ номуудаар "Шинэ номын үзэсгэлэн" гаргалаа. Үзэсгэлэнд 60 ширхэг ном гаргасан бөгөөд амьдрах ухаан, харилцаа, танин мэдэхүйн чиглэлийн номуудыг гарган үзүүллээ. Байгаль орчин аялал жуулчлалын газар, Хөвсгөл нуур – Эгийн голын сав газрын захиргаатай хамтран мөрөн сумын ЕБС – ын ахлах ангийн сурагчдын дунд "Байгаль орчин ба тогтвортой хөгжил" сэдвийн хүрээнд АСК тэмцээнийг 4 дахь жилдээ зохион байгууллаа.

Аймгийн ОНСМ нь "Музейтэй монгол" төслийн хүрээнд Дэлхийн зөн ОУБ-тай хамтран ЕБС-ий 1-5 ангийн сурагчдад музейг үнэ төлбөргүй үзүүлж байна Төслийн хүрээнд одоогоор нийт 9 сургуулийн 1000 гаруй хүүхдийг хамруулан түүх соёлын талаар мэдээлэл хүргэн ажиллаж байна.

Аймгийн хөгжимт драмын театрын дуучин Монгол Улсын Соёлын Тэргүүний ажилтан Пүрэвдоржийн Амарсайхан нь дархад нутгийн онцлогийг харуулсан "Миний нутгийн үзэсгэлэн" уран бүтээлийн тоглолтоо Улаанбаатар хотноо "Үйлдвэрчний эвлэлийн соёлын төв ордонд анх удаа амжилттай зохион байгуулж нийт 1000 гаруй үзэгчдэд толилуулж тэднээс өндөр үнэлэлт авлаа. Мөн залуу дуучин У. Лхагважаргал, С. Мөнгөнтулга, Н.Зоригтбаатар, Ж. Арвижих нар "Тэнгэр нь цэлмэг эх орон" уран бүтээлийн тоглолтоо Галт, Шинэ-Идэр, Жаргал, Төмөрбулаг сумдад хийж, Драм ангийн уран бүтээлчид "Гурван найз" таягт хүүхэлдэйн жүжгийг аймгийнхаа бүх цэцэрлэгийн 2-5 насны хүүхэд багачуудад тоглож нийт 1200 гаруй хүүхдэд тоглож хүүхэд багачууд маш ихээр сонирхож үзлээ.

Дэлхийн эмч нарын өдрийг тохиолдуулан АШУҮИС-ийн багш АУ-ын доктор, дэд профессор Ч.Баттогтох, АУ-ын доктор А.Аварзэд, АУ-ын магистр Д.Золзаяа нар "Эмнэлгийн халдварын сэргийлэлт, хяналт" сэдэвт 1 багц цагийн сургалтыг зохион байгуулсан. Сургалтанд хөдөө орон нутаг болон аймгийн төвийн 350 гаруй их, бага эмч, сувилагч, эм зүйч, эм найруулагч нар хамрагдан мэдлэг, мэргэжлээ дээшлүүлсэн ба "Сэхээн амьдруулах, мэдээгүйжүүлэлт, эрчимт эмчилгээний их эмч Х.Цэнд-Аюуш сангийн нэрэмжит "Шинэ Санаа-Шинэ Мэдлэг" сэдэвт онол практикын бага хуралд нийт 14 илтгэл

хэлэлцүүлж байр эзлүүлэн шагнаж урамшууллаа. “Эмчдаа тандаа баярлалаа” захидлын уралдаанд иргэдээс 52, хүүхдийн захидал 332, үүнээс дуу 2, ерөөл 1 тус тус ирсэн байна.

Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих хөтөлбөрийн хүрээнд Эрүүл мэндийн яам, АЗДТГ, ДЭМБ-тай хамтран “Эрүүл мэндийн салбар дундын хамтын ажиллагаа-2019” Аймгийн анхдугаар зөвлөгөөнийг зохион байгууллаа. Зөвлөгөөнд оролцогчдоос Аймгийн Засаг даргын А/531 дүгээр захирамж, ИТХТ-ын 143 дугаар тогтоолуудад санал аван цаашид хамтран ажиллах, Эрүүл мэндийн салбар дундын хамтын ажиллагааг хэрхэн сайжруулах талаар Аймгийн ИТХ-ын тогтоолын төслийг боловсруулж ажиллалаа.

Монгол улсын Засгийн газрын 2018 оны 255 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл шүд-Эрүүл хүүхэд” үндэсний хөтөлбөрийн нээлтийн үйл ажиллагааг зохион байгууллаа. Нээлтэнд ЭМГ, Нэгдсэн эмнэлгийн удирдлага, ЭМДТасаг, хувийн хэвшлийн шүдний эмнэлгүүд оролцлоо. Нэгдсэн эмнэлэг, хувийн хэвшлийн шүдний эмнэлгүүдтэй цаашид хамтран хийх ажлын төлөвлөгөөг танилцуулж саналыг авч нэгтгэн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхээс гадна сонгогдсон шүдний эмнэлгүүд хуваарийн дагуу 2-12 насны хүүхдүүдэд шүдний үзлэгийг хийж эмчлэн эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулах чиглэлийг өглөө.

Эрүүл мэндийн газрын даргын баталсан удирдамжийн дагуу эрүүл мэндийн байгууллагуудын эмч мэргэжилтнүүдийг чадавхижуулах сургалтыг 6 бүсэд хуваан зохион байгууллаа. Уг сургалтыг эмч мэргэжилтнүүдийг чадавхижуулах асуудал, сургууль цэцэрлэгийн эмч нарын сургалт, иргэдийн сургалт гэсэн үе шаттайгаар зохион байгуулсан ба бүсчилсэн сургалтад нийт 230 эмч мэргэжилтнүүд, 500 гаруй иргэд, 350 орчим СӨББ, ЕБС-ын багш ажиллагсад оролцсон байна. Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Алаг үрсээ авто ослоор алдсаар байх уу?” мэдээллийн аянд нэгдэж ЭМГ, НЭ-ийн албан хаагчдыг хамруулан оролцлоо.

ЭМГ-ын даргын баталсан “Эх хүүхдийн үзлэг, хяналт үнэлгээний багийн ажлын удирдамж”-ийн дагуу эх, хүүхдийн баг үзлэг, оношлогоо хийх, эх, хүүхдийн тусламж үйлчилгээг сайжруулах дэмжлэгт хяналт хийх, эцэг эхчүүдэд сургалт зохион байгуулах, орон нутгийн удирдлагууд, байгууллагуудын дарга, мэргэжилтнүүдийг мэдээллээр хангах, ЭМТ-ийн эмч мэргэжилтнүүдийг чадавхижуулах арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор ЭМГ-ын даргаар ахлуулсан баг 2019 оны 04-р сарын 16-20-ны өдрүүдэд Ханх суманд ажиллалаа. Эх, хүүхдийн үзлэг оношлогоонд нийт 147 иргэн хамрагдаж мэргэжлийн эмч нараас зөвлөгөө авч хамтран ажилласан байна.

Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хурлын бэлтгэл ажлыг ханган хуралдууллаа. Бэлтгэл ажлын хүрээнд хэлтсийн холбогдох мэргэжилтнүүд 6 хувийн хэвшлийн эмнэлэг, 9 эмийн санд үнэлгээ хийж ажилласан ба хуралдаанаар “Тусгай зөвшөөрөл” хүсэгч шинээр байгуулах дөрвөн ЭМБ-ын төслийг хэлэлцэж 21 ЭМБ-ын тусгай зөвшөөрлийг сунгалаа.

Олон Улсын Хөдөлмөрийн байгууллага байгуулагдсаны 100 жил, Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага байгууллага байгуулагдсаны 60 жилийн ойн хүрээнд “Хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарын нээлттэй хаалганы

өдөрлөг “улсын хэмжээнд зохион байгуулагдаж байгаа бөгөөд энэхүү өдрийг манай аймагт 3 дахь жилдээ амжилттай зохион байгууллаа. Өдөрлөгийн үеэр иргэд нэг цэгээс нийгмийн даатгал, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн үйлчилгээ, Гэр бүл, залуучуудын хөгжлийг дэмжих үйлчилгээг авахаас гадна нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг, оношлогоо, элэгний В, С вирусын шинжилгээ, сахарын шинжилгээг хийлгэж,, хөнгөлөлттэй эмийн үйлчилгээ авах боломжийг бүрдүүллээ. Мөн мэргэжлийн боловсролын талаарх мэдээлэл, ахмад настны асрамж үйлчилгээний төвийн үйл ажиллагаатай танилцах, ажил зуучлах, идэвхтэй ажил хайгчаар бүртгүүлэх зэрэг нийгмийн хамгааллын үйлчилгээг 1 дороос авч чадлаа.

Мөрөн суманд үйл ажиллагаа эрхэлж буй хүнс, барааны захуудын үйл ажиллагаанд хяналт шалгалт зохион байгуулж 7 зах, 2 худалдаа үйлчилгээний төвүүдээр үзлэг хийж, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9 дүгээр зүйл, Монгол улсын Засгийн газрын 2018 оны 7 дугаар сарын 9-ны өдрийн 01 албан даалгавар, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 03 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд 6 асуумжийн хүрээнд үнэлгээ хийлээ.

Аймгийн нэрлэсэн жилийн хүрээнд Хүүхэд, багачуудыг номонд дуртай болгох, ном унших хүсэл сонирхлыг нь төрүүлэх, номыг хайрлах, сэтгэлгээнд сургах, номоор дамжуулан амьдралын арга ухааныг олж авахад туслах, унших, чадварыг сайжруулах, нийгмийн оролцоог нэмэгдүүлэхэд зорилгоор ахлах ангийн сурагчдын дунд “Уншсан зохиолоо хэн сайн ярих вэ?” уралдаанд хэлэлцүүлгийг “Ном – бидний нөхөр” номын аяны хүрээнд аймгийн Нийтийн номын сан, Утга зохиолын нэгдэлтэй хамтран ахлах, дунд насны ангиллаар зохион байгуулсан.

Хүүхдийн оролцоо, өөрийн удирдлагын байгууллагын үйл ажиллагааг идэвхжүүлж, хүүхэд, өсвөр үеийнхнийг хорт зуршлаас татгалзуулж, эрүүл зан үйлийг төлөвшүүлэн UNFRIEND хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилготой JUICE PARTY хөтөлбөрт арга хэмжээг аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, ДЗМОУБ-ын Хөвсгөл ОНХ, АНЗХ, сургуулийн ХОӨУБ-тай хамтран зохион байгуулав.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Цагдаагийн газрын фэйж хуудас болон facebook группээр уралдаанч хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах зөвлөмж, брошур, шийдвэрүүдийг сурталчлан ажиллав.

Хүүхэд өсвөр үеийнхний авьяас чадварыг хөгжүүлж, хөгжлийг дэмжсэн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх бодлогыг баримталж, Монголын оюун ухааны академийн “Спорт өрөлт”-ийн дугуйланг хичээллүүлж эхлээд байна. Дугуйланд 90 хүүхдийг үнэ төлбөргүй хамруулан, тэдний хөгжлийг дэмжин эцэг, эхчүүдтэй хамтран ажиллаж байна.

Өсвөр үеийнхний бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, тэднийг нийгэмд хувь нэмэр оруулах идэвхтэй иргэн болгон төлөвшүүлэх, нийгмийн олон талт асуудлыг судалж, танин

мэдэх, өөрийн болон бусдын үзэл бодлыг хүндэтгэх, чөлөөтэй, нээлттэй өөрийгөө илэрхийлэх, хамтын ажиллагаа харилцааны чадварыг хөгжүүлэх, үнэт зүйлтэй хувь хүн төлөвшүүлэх зорилгоор аймгийн БСУГ, "Арвис" клубтэй хамтран КАРЛ ПОППЕРИЙН мэтгэлцээний 2019 оны аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулсан. Тэмцээнд 6 сумын 12 сургуулийн 48 хүүхэд 16 багт хуваагдан оролцож өрсөлдсөн.

Аймгийн ИТХ-ийн даргын Б/02 дугаар захирамжаар 2019 оны 2 дугаар сарын 18-ны өдрөөс Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогчдод үйлчлэх “Нэг цэгийн үйлчилгээний төв”-ийн үйл ажиллагааг эхлүүлсэн. 2019 оны 4 дүгээр сард давхардсан тоогоор 151 хүнд үйлчилгээ үзүүлээд байна

Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд:

ХХААХҮЯ-наас зохион байгуулсан “Газар тариаланчдын Улсын зөвлөгөөн”-д аймгийн Засаг дарга, ХХААГ-ын дарга, Тариалан, Эрдэнэбулган, Рашаант, Их-уул, Мөрөн, Тосонцэнгэл сумдын газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудын нийт 25 ажилтан хамрагдлаа.

Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч, төмс, хүнсний ногоо тариалагчид хаврын тариалалтад бэлтгэж, үр нарлуулах, чийг хаах борной явуулах, техник засвар үйлчилгээ зэрэг тариалалтын бэлтгэл ажлыг хийж байгаа бол төмс хүнсний ногоо тариалагчид үрсэлгээ хийж эхлээд байна.

Монголын Хүнсчдийн холбооны аймаг дах салбар зөвлөлтэй хамтран хүнсний аж үйлдвэрийн ажилтан ажиллагсадын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний хүрээнд спортын 2 төрлийн тэмцээн, ажиллагсадын бие бялдарыг хөгжүүлэх зорилгоор ажлын байрны дасгал хөдөлгөөн, бие бялдар чийрэгжүүлэлтийн сорилд хамруулах, олс таталт, буухиа тэмцээнийг Аймгийн БТСГ-тай хамтран зохион байгуулж уг арга хэмжээнд 11 байгууллагын 12 баг тамирчид бусад арга хэмжээнд 400 гаруй ажилтнууд хамрагдлаа.

2019 оны 05 сарын 01-ны байдлаар оны эхний 2545,6 мян.толгой хээлтэгч мал төллөхөөс нийт 1344309 толгой хээлтэгч төллөж, 1332531 тол.төл бойжиж байна. Үүнд: ботго 227, унага 18230, тугал -53591, хурга- 791631, ишиг 468852 толгой байна. Мал төлөлт 52,8%, төл бойжилт 99.0 хувьтай байна.

2019 оны 05 сарын 01-ний байдлаар оны эхнээс 23667 толгой мал хорогдсон. Үүнд: тэмээ 1, адуу 885, үхэр- 2172, хонь 8793, ямаа 11816 мал хорогдож үүнээс хээлтүүлэгч нийт 216 үүнээс адуу 5, үхэр 11, хонь 78, ямаа 122, өвчнөөр нийт 146, адуу 4, үхэр 24, хонь 40, ямаа 78 мал хорогдож оны эхний нийт малаас 0,4 хувь нь хорогдсон байна.

2018 онд үндэсний боловсруулах үйлдвэрт тушаасан малчин, мал бүхий этгээдэд арьс ширний урамшууллын 10808 өрхийн материалыг Мал хамгаалах санд хүргүүлснээс 8409 урамшуулалд хамрагдсан. Иймд үлдсэн 2399 өрхийн урамшуулалд хамрагдаагүй шалтгааны тодруулахаар Мал хамгаалах санд албан тоотоор хүргүүлээ

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд Биокомбинатад УТҮГ-аас нэг удаагийн татан авалтаар улсын төсвийн санхүүжилтээр 3 нэрийн 8,2 сая төгрөг, орон нутгийн 3 нэрийн 46,3 сая төгрөг, хувь хүн иргэн хуулийн итгээдийн санхүүжилтээр 1

нэрийн 785,1 мянган төгрөгийн вакциныг өмч хамгаалах ажлын хэсгийн бүрэлдэхүүн хүлээн авч, вакцины хүйтэн хэлхээг таслахгүйгээр тусгай хөргүүртэй машинаар 4 сумын 15 аж ахуйн нэгжийн 6-н нэрийн 14.8 сая төгрөгийн вакциныг түгээлтээр сумын тасгийн хөргүүрт хүлээлгэж өглөө.

УМЭАЦЛТ-рийн 19-923 дүгнэлтээр гахайн африкийн мялзан өвчин оношлогдож, аймгийн Засаг даргын захирамжаар холбогдох арга хэмжээг авч ажиллан гахайтай 5 сумын 33 өрх, 1 аж ахуйн нэгжийн 553 тэжээвэр болон зэрлэг гахайд идэвхитэй тандалтыг байнга хийж байна. Халдвартын тасагт давхардсан тоогоор 14 сумын 24 экспертизээр 73 дээжинд оношлогоо шинжилгээ хийгдэж, B052 өвчний тохиолдол 3, B160 өвчний тохиолдол 2, B55 өвчний тохиолдол-1, B202 өвчний тохиолдол-1 нийт 7 өвчний тохиолдол оношлогдож холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.

Зургаа. Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд:

БОАЖ-ын сайдын санаачилгаар хэрэгжиж байгаа “Хандлагаа өөрчилье” багц ажлын хүрээнд 2018 оноос эхлэн ЕБС-ын ахлах ангийн сурагчдад Ногоон паспортыг хөтлүүлж эхэлсэн ба 2019 оны 04-р сард эдгээр ногоон паспорт эзэмшигч сурагчдын төлөөлөл 7 сурагчийг ОУ-ын хүүхдийн “Найрамдал” зусланд амрааж, сургалтанд хамруулж, бусад хүүхдүүдээс туршлага судлах боломжийг олголоо.

Дэлгэрмөрөн голын сав дагуу хяналт шалгалт, хар галуу үргээх ажлыг Мөрөн сум, Дэлгэрмөрөн Шишхэд голын сав газартай хамтран зохион байгуулсан.

Ойн тухай хуулийн 18.3.1-т заасны дагуу 2019 оны 1-р улирлын байдлаар мод бэлтгэлийн талбай тусгаарлалтын ажлыг 4 сум дундын ойн ангиуд хариуцсан сумдадаа нийт 636,1 га талбайд хийж гүйцэтгээд байна. Үүнд:

- “Дэлгэрмөрөн” сум дундын ойн анги – 264 га
- “Нарс Шинэсэн төгөл” сум дундын ойн анги- 174,1 га
- “Баяншишгэд” сум дундын ойн анги- 167 га
- “Эрчимт-Идэр” сум дундын ойн анги- 31 га

Аймгийн хэмжээнд 2019 оны 1-р улирлын байдлаар 40 ойн мэргэжлийн байгууллага, 10 ойн нөхөрлөлд 636,1 га талбай тусгаарлаж 3357 м3 хэрэглээ, 15457,4 м3 түлээ нийт 18814,4 м3 мод бэлтгэсэн байна. Мод бэлтгэлийн явц 3,7 хувьтай байна.

Долоо. Сум, орон нутгийн талаар

Аялал жуулчлал, хөдөө аж ахуй, боловсрол, хот байгуулалт, төлөвлөлт чиглэлээр хамтран ажиллах санамж бичигт Мөрөн сумын Засаг дарга Ц.Гансүх, БНХАУ-ын Лиао Нин мужийн Даньдун хотын дарга Жан Шү Пин нар гарын үсэг зурлаа.

Мөрөн сумын ЗДТГ, ХБНГУ-ын Барут Марк хоттой хамтран олон төслүүдийг хэрэгжүүлж байгаа билээ. Энэ удаад Мөрөн хотын хог хаягдлын менежментийг сайжруулах төсөл хөтөлбөрийг эхлүүлж, Барут Марк хотоос Өмнөд Бранденбургийн хог хаягдлын холбооны дарга Ноён Пэцолд, “БН Байгаль орчин” ХХК-ийн захирал Франк

Цоернер, Барут Марк хотын хөгжлийн бодлогын зохицуулагч Виттке нар хүрэлцэн ирж хог хаягдлын төвлөрсөн цэгийн үйл ажиллагаатай танилцлаа. Мөрөн сумын ЗДТГ, “Мөрөн ХТҮТ” ХХК-ны мэргэжилтэн, Хатгал тосгоны Захирагчийн ажлын алба, аймгийн холбогдох газрын удирдлага мэргэжилтнүүдтэй уулзалт хийж төслийн эхний танилцуулга, цаашид хийх ажлын талаар санал солилцлоо.

Аялал жуулчлал, хөдөө аж ахуй, боловсрол, хот байгуулалт, төлөвлөлт чиглэлээр хамтран ажиллах санамж бичигт Мөрөн сумын Засаг дарга бөгөөд хотын захирагч Ц.Гансүх, БНХАУ-ын Лиан Нин мужийн Даньдун хотын дарга Жан Шү Пин нар гарын үсэг зурлаа.

Мөрөн сумын засаг дарга Ц.Гансүхийн санаачлагаар “ Хүүхэд хамгаалал, өрхийн хөгжлийг дэмжих жил”-ийн хүрээнд Мөрөн сумын хамгийн олон хүүхэдтэй, амьдралын баталгаажих түвшингээс доогуур орлоготой 210 өрхийн амжиргааг бодитойгоор дэмжих зорилгоор “Халуун сэтгэл” сайн үйлсийн тугийг албан байгууллага, ААН-үүдээр аялуулж эхэллээ. Уг ажлын хүрээнд Голом банкны хамт олон 8 өрхийн 26 хүүхдэд хичээлийн хэрэгслээр тусламж дэмжлэг үзүүллээ.

Мөрөн сумын багуудын хэсгийн ахлагч нарын зөвлөгөөнийг баг тус бүрт зохион байгууллаа. Зөвлөгөөнд Аймаг сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг танилцуулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөршийн холбооны ажиллах чиглэл зэрэг төрийн үйл ажиллагааг сурталчлан, сумын удирдлагууд болон холбогдох хэлтэс, агентлагууд оролцож цаашид хэсгийн ахлагч нартай хамтран ажиллах гэрээ байгууллаа.

Тариалан сумын Засаг даргын Тамгын газраас “ Хүрч үйлчилье- Иргэдээ сонсьё” нээлттэй өдөрлөг арга хэмжээг 2019 оны 3 дугаар сарын 21-ээс 3 дугаар сарын 24-ний өдрүүдэд “Хамтын оролцоо- Хариуцлагатай засалал”, “Иргэн төвтэй- Төрийн үйлчилгээний жил”- д төрийн үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй хүргэж, бодлого зорилтоо сурталчлах, иргэдийн санал хүсэлтийг сонсох зорилгоор тусгай удирдамжаар зохион байгуулж, 21 төрлийн мэдээлэл хийж, хөгжөөнт буухиа, цэнгээнт бүжиг, АХА тэмцээн явуулж, уг арга хэмжээнд хөдөөгийн 5 багийн 377 иргэн хамрагдав. Мөн уг өдөрлөгөөр сэтгэл ханамжийн судалгаа авч ажиллалаа.

Хүүхэд хамгаалал- Өрхийн хөгжлийн дэмжих жил”, “Нэг хором- Инээмсэглэл- Хүндлэл - Уучлал” 21 хоногийн аяны хүрээнд 15 залуу гэр бүлийн 30 иргэдэд уулзалт, сургалтыг тусгай удирдамжаар зохион байгууллаа. Аяны хүрээнд соён гэгээрүүлэх уулзалт, ярилцлагыг тусгай удирдамжаар Сэтгэл зүйч н.Содномбямбаа, аймгийн Хяналтын прокурор П.Итгэл нар хийсэн ба архины хамааралтай 15 иргэнтэй уулзаж, 13 иргэн өөрсдийн хүсэлтээр хордлого тайлах эмчилгээ хийлгэж, 8 иргэн ганцаарчилсан сэтгэл зүйн, зөвлөгөө авлаа. 9-12 дугаар ангийн 105 охидод “Эмэгтэй хүн байхын учир”, 54 хөвгүүдэд “Өнөөгийн нийгэм болон цахим орчны хэрэглээ” мэдээлэл уулзалт зохион байгуулав.

Бүрэнтогтох суманд “Хүүхэд хамгаалал-Өрхийн хөгжлийн дэмжих” нэрлэсэн жилийн хүрээнд аймгийн МСҮТ-ийн хамт олон ирж "Мэргэжлийн боловсрол ба залуучуудын хөдөлмөр эрхлэлт" мэргэжил сурталчлах уулзалт, өдөрлөгийг амжилттай

зохион байгуулж хамтран ажиллалаа. Энэ үеэр бага насны хүүхдүүдтэй өрх толгойлсон хашаа, хаалгыг шинэчлэн засварлаж, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн авто машиныг оношилж засварласан байна. Мөн Засаг даргын Тамгын газрын ажилтнууд ажлын хэсэг байгуулж удирдамжийн дагуу 4 чиглэлд хуваагдаж Баянхошуу багийн нийт 180 өрхөөр орж цаг үеийн ажил, төрийн бодлого шийдвэрийг сурталчлан нийт 46 иргэдийн саналыг хүлээн авч, 24 саналыг бүрэн шийдвэрлэсэн байна. Бүрэнтогтох, Цагаан-Уул, Цэцэрлэг сумдын ИТХ, багийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын хамт олон “Харилцан судалж-Хамтдаа хөгжье” уриан дор бүсийн уулзалт зөвлөгөөн, уралдаан тэмцээнийг 4 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгуулж Бүрэнтогтох сум тэргүүн байр эзэлж Шилжин явах цом авлаа.

Шинэ-Идэр суманд нэрлэсэн жилийн ажлын хүрээнд анхаарал халамж зайлшгүй шаардлагатай хүүхэдтэй 5 өрхийг байгууллагуудад хариуцуулан хамтран ажиллаж байна. Өрх бүрийг угийн бичиг хөтлүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор “Угийн бичиг хөтлөх арга зүй” сэдвээр цэргийн насны залуучууд болон иргэдэд сургалт явуулж, ярилцлага зохион байгуулав. Сургалтад 102 хүн хамрагдсанаас 18 өрх угийн бичиг хөтөлж эхэлсэн байна.

Алаг-Эрдэнэ суманд ЗИС-30 аяныг зарлан Засаг даргын Тамгын газрын албан хаагчид ЗДТГ-ын гүний худгийн дотор, гадна талыг засварлах, гудамж талбайн хашаа, саадыг будаж засварлах, Тамгын газрын хүлэмжийг сэргээн засварлах зэрэг бүтээлч ажлуудыг эхлүүлэн хийж хэрэгжүүлж байна.